



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/262

Улаанбаатар хот

**Хан-Уул дүүргийн 114 дүгээр  
сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг  
данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 27,263,983 (хорин долоон сая хоёр зуун жаран гурван мянга есөн зуун наян гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 114 дүгээр сургууль (Д.Ган-Уяа)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 12,910 ширхэг 27,263,983 (хорин долоон сая хоёр зуун жаран гурван мянга есөн зуун наян гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 114 дүгээр сургууль (Д.Ган-Уяа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)- д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000785

